

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

---

№ 18/4

Улаанбаатар хот

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ээлжит бус хуралдааныг хийж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан удирдав. Хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг өөрчлөх эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд эдийн засгийн өнөөгийн болон ойрын ирээдүйн төлөв, инфляци, эдийн засгийн өсөлт, гадаад эдийн засгийн орчин, хөрөнгө санхүүгийн зах зээл, эдгээрт гарч буй өөрчлөлтүүдийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулав.

Инфляци 2018 онд харьцангуй тогтвортой байж, зорилтот түвшний орчимд байгаа ч, дотоод эрэлт, шатахууны үнэ болон валютын ханшийн нөлөөгөөр 2019 оны сүүлийн хагаст зорилтот түвшинг давах төлөвтэй байгааг МБГ-аас онцлов. Нийлүүлэлтийн шалтгаанаар махны үнэ 2018 оны төгсгөлд өндөр байхаар байна. Харин 2019 онд цаг агаар олон жилийн дундаж төлөвт хадгалагдана гэж үзвэл төсөөллөөр нийлүүлэлтийн хүчин зүйл эрчимжихээргүй, хүнсний инфляци тогтворжихоор байгаа бол өрхийн орлого, засгийн газрын хэрэглээ тэлэхээр байгаагаас дотоод эрэлт нэмэгдэж, хүнсний бус инфляци нэмэгдэхээр байгааг танилцууллаа.

Суурь төсөөллөөр уул уурхайн салбар 2018 онд агшиж, уул уурхайн бус салбарын өсөлт хадгалагдан, эдийн засгийн идэвхжил үргэлжлэхээр байна. Зэсийн баяжмал дахь алтны агууламж сэргэх ч, хил дээрх саатлын улмаас нүүрсний экспорт оны сүүлч рүү саарч уул уурхайн салбарт сөргөөр нөлөөлөхөөр байна. Энэ нь 2018 онд тээврийн салбарт сөргөөр нөлөөлөх ч, хурдтай өсч буй импорт, Оюу толгойн хөрөнгө оруулалт зэрэг нь тээвэр болон барилгын салбарын өсөлт, гаалийн татварын орлогыг нэмэгдүүлж, улмаар эдийн засгийн өсөлт өмнөх оноос өндөр байхаар байна. Харин 2019 онд түүхий эдийн үнийн төсөөлөл сайжирсан нь уурхайн үйлдвэрлэлийг бага хэмжээгээр өсгөхөөр байгаа бол төсвийн урсгал болон хөрөнгийн зардал тэлж, боловсруулах, үйлчилгээ, барилгын салбаруудыг дэмжсэнээр уул уурхайн бус салбарын өсөлт хадгалагдах төлөвтэй байна.

МБГ-ын танилцуулснаар гадаад эдийн засгийн төлөв хүлээлтээс муудсан байна. Үүнд Хятадын эдийн засгийн өсөлт 2018 онд хүлээлтээс бага буюу 6.4 хувь, Евро бүсийн эдийн засаг 1.7 хувь, ОХУ-ын эдийн засаг 1.9 хувиар өсөхөөр байгаа нь голлон нөлөөлжээ.

Мөн төлбөрийн тэнцэл 2018 онд алдагдалтай хэдий ч хуримтлуулсан мөнгөжсөн алтны нөлөөгөөр ГВАН нэмэгдэхээр, 2019 онд төлбөрийн тэнцэл ашигтай байх төсөөллийг танилцууллаа. Энэ онд экспортын гол түүхий эдийн үнэд харьцангуй өндөр байсан ч 11 дүгээр сарын сүүлийн хагасаас манай улсын хилээр гарах нүүрсний экспортын хэмжээ хязгаарлагдаад байгаа нь экспортын орлогын тооцоо өмнөх төсөөллөөс буурав. Мөн эдийн засаг идэвхжиж, импорт үргэлжлэн тэлсээр байгаа нь урсгал тэнцлийн алдагдлыг өсгөж байна. Харин энэ оны 10 дугаар сард Хөгжлийн банк 500 сая ам.долларын бондыг гадаад зах дээр босгосон нь 2018 оны санхүүгийн дансны орох урсгал, улмаар төлбөрийн тэнцэл өмнөх төсөөллөөс сайжрахад нөлөөлсөн байна. 2019 онд түүхий эдийн үнийн төсөөлөл

өмнөх төсөөллөөс бага зэрэг сайжирсан ч, цаашид буурах хандлага хэвээр байгаа; БНХАУ-ын өсөлт саарч, гадаад эрэлт буурахаар байгаа; мөн ирэх онд төсвийн хөрөнгө оруулалтын зардалтай уялдан барилгын материалын импорт үргэлжлэн тэлэх тул урсгал тэнцлийн алдагдлын төсөөлөл нэмэгдэж ДНБ-ий 15 хувьд хүрэхээр байгааг танилцуулав. Харин Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт үргэлжлэх, ОУВС-гийн ӨСХ-ийн санхүүжилтүүд хуваарийн дагуу орж ирэх нь манай улс руу орох гадаад валютын урсгалыг тэтгэж, төлбөрийн тэнцлийг ашигтай гарахад нөлөөлнө. Гэхдээ манай улсын хил, гаалийн хүндрэл цаашид үргэлжилбэл нүүрсний экспорт буурах, цаашлаад хөрөнгө оруулагчдын итгэл болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бууруулж, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байгааг МБГ-аас танилцуулав.

Мөнгөний үзүүлэлтүүд 2018 оны 3 дугаар улиралд үргэлжлэн өсч, зээлийн өрийн үлдэгдэл 20 хувиар нэмэгдэв. Тухайлбал, өрхийн хэрэглээний зээлийн үлдэгдэл тайлант улиралд 46 хувиар нэмэгдэж мөнгөний агрегатын өсөлтөд голлон нөлөөлөв. Ингэснээр нийт банкны системийн зээлийн 25 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Гэхдээ 2019 оны эхнээс иргэдийн хэрэглээний зээлийн Өр-орлогын харьцааг 70 хувиар хязгаарлаж эхлэх тул цаашид хэрэглээний зээлийн өсөлтийн хурд саарахаар хүлээгдэж байна.

Танилцуулгын төгсгөлд төсөөллийн тодорхой бус байдлыг хэлэлцэв. Дотоод орчны хувьд нийлүүлэлт талаас цаг агаарын нөхцөл байдал, шатахууны үнийн зохицуулалт, эрэлт талаас нүүрсний экспортын хязгаарлалт, цалин нэмэгдэх, томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтууд нэмэгдэх зэрэг тодорхой бус байдлуудыг онцолсон бол гадаад эдийн засгийн хувьд геополитикийн асуудлууд болон АНУ, БНХАУ хоорондын худалдааны зөрчилдөөн, түүний экспортын барааны үнэнд үзүүлэх нөлөө зэрэг нь тодорхой бус байдлын гол эх сурвалж болж байгааг МБГ онцоллоо.

МБГ-ын суурь төсөөллөөр 2019 онд инфляцийн түвшин 8.5 хувь, эдийн засгийн өсөлт 6.8 хувь байхаар байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляци алгуур нэмэгдэх хэдий ч 2020 онд инфляци зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байгааг онцлов. Суурь төсөөллөөс гадна бодлогын хүүг өсгөх, манай улсын хилээр нэвтрэх нүүрсний экспортын хэмжээ хязгаарлагдаад байгаагаар холбоотойгоор нүүрсний экспортын хэмжээ 2019 онд буурах, улмаар хөрөнгийн урсгал татрах хувилбаруудыг мөнгөний бодлогын газар танилцуулав. Үүсээд байгаа нөхцөл байдалтай уялдан эдгээр хувилбарууд биелэх магадлал багагүй болохыг онцоллоо.

Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 11 хувьд хүргэх санал гаргасан. Гишүүд мөнгөний бодлогын газрын саналыг хэлэлцэж, энэ удаагийн ээлжит бус хуралдаанаар гарах бодлогын хүүний шийдвэр нь цаг үеэ олсон шийдвэр гэдэгтэй санал нэгдэж байгаагаа илэрхийлсэн. Тодруулбал, манай улсын гадаад орчны тодорхой бус байдал харьцангуй өндөр, нүүрсний экспорт удаашрах хандлага үүсээд байгаа бөгөөд энэ хандлага хэдий хүртэл үргэлжлэх нь тодорхой бус байгааг онцолсон.

Мөн Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ шат дараатайгаар өсгөж байгаа өнөө үед хөгжиж буй улсуудаас хөрөнгийн урсгал гадагшилж, бодлогын хүүгээ дагаж өсгөх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Ийнхүү Мөнгөний бодлогын хорооны гишүүд төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэн, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг хамгаалж, макро эдийн засгийн дунд хугацааны

тогтвортой байдлыг хадгалах чиглэлийн хүрээнд бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 11 хувьд хүргэх саналыг 100% дэмжлээ.

Хурлын сүүлийн хэсэгт мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулах зорилгоор 28 долоо хоногтой ТБҮЦ-ыг арилжаанд нэвтрүүлж, хоёр долоо хоногт нэг удаа Лхагва гаригт, хэмжээ хязгаарласан, хүүгээр өрсөлдөх хэлбэрээр зохион байгуулах гэж байгааг Монголбанкны НУСЗЗГ танилцуулав. Энэхүү арга хэмжээ нь барьцаат хэлцлийг хөгжүүлж, банк хоорондын захын идэвхийг нэмэгдүүлнэ хэмээн хүлээж байгаагаа илэрхийлэв.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны Мөнгөний Бодлогын Хороо 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж 11 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Бодлогын хүүний шийдвэрийг 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн мөрдүүлэхээр тогтов.